

НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү Премиум Нэксус ХК (“Компани” гэх)-ийн Нэгдсэн менежментийн тогтолцоо (“НМТ” гэх)-ны бодлого (“Бодлого” гэх) нь НМТ-оог Компанийн үндсэн стратегийн зорилттой уялдуулан удирдах үндсэн баримт бичиг байна.

ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү Бодлого нь Компанийн доорх байршлуудад хамаарна. Үүнд:

- Төв оффис – Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26 хороо, Сакура Тауэр, 7-р давхар
- Салбар дэлгүүрүүд
- Түгээлтийн төв энгийн бүтээгдэхүүн – Улаанбаатар 16103, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн бүс 4,
- Түгээлтийн төв хүйтэн хэлхээний түгээлтийн төв – Улаанбаатар 13090, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Хонхрын 82.

БОДЛОГО

Бид хэрэглэгчдэдээ үргэлж нээлттэй, ойр байж, хэрэглэгчийн хүсэл сонирхлыг байнга сонсох замаар хувьсан өөрчлөгдөж буй хүлээлт хэрэгцээ шаардлагад нь нийцэн, тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудыг баримталж, холбогдох хууль эрх зүй, зохицуулалтын шаардлагыг хангасан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тасралтгүй хангаж, хүн ба хүрээлэн буй орчинд ээлтэй сонирхогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг ямагт нэн тэргүүнд чухалчлан эрх ашгийг дээдлэн ажиллаж, чин сэтгэлээсээ найрсгаар үйлчлэн хэрэглэгчийнхээ хамгийн итгэдэг брэнд болох зарчмыг баримтална.

Ажилтан

Ажилтан бүрийг хувь хүн болон мэргэжлийн талаасаа өсөж хөгжих боломжийг олгодог, хүртээмжтэй ялгаварлалгүй ажлын орчныг бий болгохыг эрмэлздэг, харилцан итгэлцэл, хүндэтгэлд суурилсан, тасралтгүй шинийг эрэлхийлэх замаар инновац, багийн хамтын ажиллагааг дэмжсэн эрүүл байгууллагын соёлыг эрхэмлэж, нийт ажилтнуудынхаа сэтгэл ханамж, амьдралын чанарыг сайжруулахын төлөө чармайн ажиллана.

Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Бид хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөхийн зэрэгцээ шинэ, олон төрлийн бүтээгдэхүүний сонголтыг санал болгох замаар тасралтгүй сайжруулалт хийж, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэхийн тулд салбар дэлгүүрээ цэвэрхэн, эмх цэгцтэй байлгаж, хэрэглэгчдэд таатай худалдан авалт хийх орчныг бүрдүүлэн ажиллахыг эрмэлзэнэ.

Хариуцлага

Төрийн хууль тогтоомж, компанийн засаглалын кодексийг чандлан биелүүлж, хүний эрх, эрх чөлөө, хүйс болон хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлыг дээдлэн, нийгэм байгаль орчиндоо ээлтэй байх зарчмыг баримтлан хэрэглэгч, харилцагч, ажилтнуудаа эрүүл, аюулгүй орчноор хангаж ажиллана.

Хамтын ажиллагаа

Өөрийн хамтрагч, бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагааг стандарт шаардлагад нийцүүлэхийг эрхэмлэн, итгэлцэл дээр суурилсан харилцан ашигтай хамтын хөгжлийг

чухалчлан, аюул осолгүй үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулахыг дэмжин, шударга бизнесийн цэвэр, ил тод байх орчныг бүрдүүлэхийг эрмэлзэн харилцан хүчин чармайлт гарган ажиллана.

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийг хүндэтгэн, компанид ашигтай хөрөнгө оруулалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх / дээшлүүлэх/ замаар хувьцаа эзэмшигчдийг урт хугацааны ашигт ажиллагаагаар ханган ажиллахад бүх хүчээ дайчлан ажиллана.

Манлайлал

Ил тод, зөв шударга удирдлагын арга барилаар компани тогтвортой хөгжүүлж, компанийн зах зээлийн үнэлгээг тогтмол нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажиллана. Үйл ажиллагаандаа чанарын стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд эрмэлзэнэ.

Дэвшилтэт техник технологи, автоматжуулалтыг бизнес процесст оновчтой нэвтрүүлж өөрийн үйл ажиллагаа, бизнес процесс, чанарын удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан урт хугацааны тогтвортой үр дүнд төвлөрөн ажиллана.

Баримтлах зарчим

- Бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд үйлчлүүлэгчийн хэрэгцээ, хүлээлтийг хангахад чиглэсэн шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бүхнээ хийнэ.
- Бид хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээнд нийцэж ажиллана.
- Бид харилцан итгэлцлийн үндсэн дээр бүх хамтран ажилладаг компаниудаа ялгалгүй харилцан чухал бизнесийн хамтрагч хэмээн үзэж, ижил тэгш боломж олгож, хамтдаа хөгжихийг эрмэлзэнэ.
- Бид бүх оролцогч талуудтай харилцахдаа тэгш шударга, ёс зүйтэй харилцана.
- Бид ил тод, шударга удирдлагын арга барилаар компаниа тогтвортой хөгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн, урт хугацааны үр өгөөжөөр хангахыг хичээж ажиллана.

Бид харилцан итгэлцэл, хүндэтгэлд суурилсан, хүний эрхийг дээдэлсэн эрүүл байгууллагын соёлыг бий болгож, нийт ажилтнуудын амьдралын чанарыг сайжруулахыг эрмэлзэнэ.